

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн
2015 оны ажлын ТАЙЛАН

2015,12,29

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний Зөвлөл 2015 оны ажлын төлөвлөгөөний төсөл боловсруулан оны эхэнд Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн батлж мөрдөн ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн 2015 оны жилийн ажлын төлөвлөгөөнд 16 ажил, асуудал төлөвлөгдөж, төлөвлөсөн ажлууд хугацаандаа бүрэн хэрэгжлээ..

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний Зөвлөлийн ээлжит хуралдааныг 2015 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр хуралдуулж Аймгийн цагдаагийн газрын 2014 оны жилийн ажлын тайланг хэлэлцлээ.

Тайлан хэлэлцэх Зөвлөлийн хуралд Цагдаагийн байгууллагын удирдлагууд, зарим ажилтнууд оролцож зөвлөлийн гишүүдийн асуултад тодорхой тайлбар, хариултууд өглөө.

Зөвлөлийн хурлаас Цагдаагийн байгууллагад зөвлөмж гаргаж хүргүүлээ.

Аймгийн цагдаагийн газар Иргэний зөвлөлд тайлангаа тавихдаа ач холбогдол өгч 2014 оны ажлын тайлангаа зөвлөлийн гишүүдэд бүрэн эхээр нь ирүүлж танилцуулсны дээр Зөвлөлийн хуралд товчилсон байдлаар судалгаа тооцоотой, дүгнэлттэй танилцууллаа.

Цагдаагийн байгууллагын 2014 оны ажлын тайлан хэлэлцээд өгсөн зөвлөмжийг аймгийн ИТХ-ын дарга, Ажлын алба, Цагдаагийн ерөнхий газар, Хууль зүйн яаманд тус тус албан тоотоор хүргүүллээ.

Цагдаагийн байгууллагын тайлан хэлэлцээд өгсөн зөвлөмжийг Аймгийн ИТХ-ын мэдээллийн самбарт тавьж иргэдэд мэдээлэл хүргэлээ.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарь батлан мөрдөн ажиллаж байна.

Ажил үүргийн хувиараар Иргэний зөвлөлд хууль, дүрмээр олгогдсон эрх хэмжээний хүрээнд хийгдэх 20 төрлийн ажил үүргийг зөвлөлийн гишүүн тус бүрт хувиарлан харицуулж, Зөвлөлийн гишүүд хуваарийн дагуу ажлуудаа бүрэн биелүүлж ажиллаж байна.

Зөвлөлийн ээлжит хоёрдугаар хуралдааныг 2015 оны 06 дугаар сарын 09-ны өдөр хуралдуулж зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийн хэрэгжилтийн явц байдлын талаар мэдээлэл хийж, цаашид ажиллах талаар үүрэг чиглэл өглөө.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөл нь Иргэний зөвлөлийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4,1,4,2 дахь заалтыг баримтлан ээлжит хурлыг 4 удаа, ээлжит бус хурлыг ажлын шаардлагаар 2 удаа тус тус хуралдууллаа.

Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21,7 дахь хэсэгт заасныг баримтлаг Олон нийтийн цагдаагийн ажилтны зарим асуудал, тэдний

урамшуулал, үнэмлэх, дүрэмт хувтасны талаар Хууль зүйн сайдад албан тоотоор асуудал тавилаа.

Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21,6,3 дахь заасан эрхийн хүрээнд Гэмт хэрэг, зөрчлийн талаарх өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шалгах, шийдвэрлэх үйл ажиллагааны талаар иргэдийн санал, хүсэлтийг авах хайрцгийг Цагдаагийн газар дээр байрлуулж ажилууллаа. Уг хайрцгаар ирсэн иргэдээс тавьсан асуудлын талаар арга хэмжээ авч анхаарч ажиллах талаар Цагдаагийн газарт албан тоотоор хүргүүллээ.

Аймгийн цагдаагийн байгууллагын алба хаагч ажилтнуудын боловсрол, ажиллах нөхцөл нийгмийн баталгааны өнөөгийн байдлын талаар зарим судалгааг гаргуулан авлаа.

Цагдаагийн алба хаагчдын 2015 оны сургалтын төлөвлөгөө, хөтөлбөртэй танилцаж заавар, зөвлөмж өглөө.

Цагдаагийн Ерөнхий газраас албан тоотоор хүссэний дагуу Зөвлөлийн гишүүдийн талаарх зарим судалгааг ирүүлсэн албан тоот, хавсралт маягтын дагуу гаргаж хугацаанд нь хүргүүллээ.

Иргэний зөвлөлийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4,14 дэх заалтын дагуу Зөвлөлийн 2014 оны жилийн ажлын тайлан, 2015 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө зэргийг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн баталж Аймгийн ИТХ-ын дарга, Ажлын алба, Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газарт тус тус оны эхэнд хүргүүлсний дээр Аймгийн ИТХ-ын мэдээллийн самбарт тавилаа.

Аймгийн цагдаагийн газрын 2015 оны хагас жилийн ажлын тайланг 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдөр сонсож зөвлөлийн 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 10 дугаар албан тоотоор 4 төрлийн зөвлөмж хүргүүллээ. Цагдаагийн байгууллагын 2015 оны эхний хагас жилийн тайлан хэлэлцсэн тухай болон өгсөн зөвлөмжийг хууль зүйн яам болон Цагдаагийн ерөнхий газар, аймгийн ИТХ-ын дарга, ажлын алба зэрэгт албан тоотоор хүргүүллээ.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөл нь 2015 оны эхний хагас жилд хууль, дүрмээр олгогдсон эрх хэмжээний хүрээнд 10 асуудлаар 4 байгууллага, нэгжид 15 албан тоот хүргүүлж 3 албан тоот хүлээн авч харилцаж ажиллаа.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлөөс 2016 онд зохион байгуулж хийх ажлын төлөвлөгөө боловсруулж иргэний зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит бус хурлаар хэлэлцэж баталлаа, батлагдсан төлөвлөгөөний хувийг аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албаны дарга, ИТХ-ын ажил хариуцсан мэргэжилтэн нарт хүргүүлж, ИТХ-ын мэдээллийн самбарт тавилаа.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн үйл ажиллагаа болон Цагдаагийн албаны тухай хууль, аймгийн Цагдаагийн газрын үйл ажиллаганы талаар орон нутгийн МВС, САМА телевизэд ярилцлага өглөө.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөл нь 2016 оны иргэний зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийн төслийг боловсруу

Зөвлөлийн хурлаар хэлэлцэн ИТХ-ын дарга, Ажлын албанд 2015 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 08,09-р тоотуудаар хүргүүлсэн боловч нэг ч төгрөгийн төсөв баталж өгөөгүй болно.


Холбогдох хууль , тогтоомжуудад зөвлөлийн гишүүдэд зохих хэмжээний урамшуулал олгох ёстой байдаг гэвч 2014 онд байгуулагдсанаас хойш өнгөрсөн нэг жил гаруйн хугацаанд 2015 оны 8-дугаар сард зөвлөлийн гишүүдэд 20,0-45,0 мянган төгрөгийн урамшил нэг удаа олгосноос өөр нэг ч төгрөгийн урамшил олгоогүй болно.

Цаашид тавих санал :

1. Хууль зүйн сайдын 2014 оны А/89 дүгээр тушаалаар баталсан Иргэний зөвлөлийн дүрэмд заасны дагуу Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн гишүүдийг аймгийн ИТХ болон Цагдаагийн байгууллагаас зохион байгуулж байгаа сургалтад хамруулах талаар анхаарч ажиллах .
2. Цагдаагийн албаны хууль болон зөвлөлийн ажиллах дүрэмд заасны дагуу Иргэний зөвлөлийг зохих хэмжээний төсөвтэй байлгаж. Зөвлөлийн гишүүдэд хууль , дүрэмд заасны дагуу зохих хэмжээний урамшил олгодог байх.
3. Зэргэлдээх аймгийн Иргэний зөвлөлийн ажлын арга барил туршлагыг судлах ажилтай нь танилцхад дэмжлэг үзүүлэх .
4. Гадаадын аль нэг орны ижил төстэй байгууллагын ажлын арга барил, туршлагыг судлах, хамтын ажиллагаа тогтооход дэмжлэг үзүүлэх.
5. Иргэний зөвлөлийг хэвлэмэл хуудас , тэмдэгтэй болгох.

Тайлан бичсэн Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн

ДАРГА



Н. ГЭЖЭЭ